




СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД,
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ
ҮҮРГИЙГ 2025 ОНД ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД, ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГАТАЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2025 ОНД
ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны дүгээр
сарын -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү гэрээг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин** /цаашид “Сайд” гэх/, нөгөө талаас **Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр** /цаашид “Засаг дарга” гэх/ нар Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.6, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, Захиргааны ерөнхий хуулийн 52.2.5, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.11 дэх заалтыг тус тус үндэслэн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах, эрх үүрэг, хүрэх үр дүн, түүнийг үнэлэх, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ТАЛУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээгээр талууд Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль болон салбарын бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

2.3. Энэхүү гэрээний 1 дүгээр хавсралтад заасан “Нийтлэг арга хэмжээний жагсаалт” 2 дугаар хавсралтад заасан “Соёл, урлаг, соёлын өвийн арга хэмжээ”, 3 дугаар хавсралтад заасан “Биеийн тамир, спортын арга хэмжээ”, 4 дүгээр хавсралтад заасан “Аялал жуулчлалын арга хэмжээ”, 5 дугаар хавсралтад заасан “Залуучуудын хөгжил, оролцооны арга хэмжээ”, 6 дугаар хавсралтад заасан “Салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-г хэрэгжүүлнэ. Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

ГУРАВ. СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний хоёрдугаар хэсэгт заасан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодлогын удирдамж, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллана.

3.2. Соёл урлаг, биеийн тамир, спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх, түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэхэд зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.3. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын байгууллагуудын санхүүжилтийг олгоно.

3.4. Энэхүү гэрээний хагас, бүтэн жилийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцана.

ДӨРӨВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Энэхүү гэрээний хоёрдугаар хэсэгт заасан нийтлэг чиг үүргийг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.2. Аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд батлагдсан соёл, урлаг, соёлын өв, биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудыг хөгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангана.

4.3. Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд энэхүү гэрээний хавсралтад заасан зорилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүү, хөрөнгө оруулалт, хүний нөөц, удирдлага зохион байгуулалтын ажлыг тусгаж, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллана.

4.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө (2022-2032 он)-ний хүрээнд хавсралтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

4.5. Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үндэсний, сонгодог, язгуур урлагийг хөхиүлэн дэмжих, иргэдэд соёлын боловсрол олгох хүрээнд хавсралтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангана.

4.6. “Монгол өв ба дэлхий дахин” хөтөлбөрийн хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлнэ.

4.7. Нутаг дэвсгэрийн хүн амыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, хүртээмжийг сайжруулах хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж биеийн тамир, спортыг хөгжүүлнэ.

4.8. Жуулчдын урсгалыг татах, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж, жуулчдыг татах Бүтээлч хотын хөгжлийн суурийг бэхжүүлнэ.

4.9. Залуучуудын хувь хүний хөгжил, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчинг сайжруулж, түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх хүрээнд хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлж залуучуудын хөгжил, оролцоог дэмжинэ.

4.10. Төсвийн жилийн дундуур соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын байгууллагуудын орон тоо болон төсөв нэмэгдүүлэх шийдвэр гаргахгүй, гаргасан тохиолдолд орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

4.11. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18 дахь заалтад заасны дагуу салбарын орон нутгийн өмчийн байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварт шаардагдах төсвийг хариуцна.

4.12. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын дагуу салбарын орон нутгийн өмчит байгууллагыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.

4.13. Аймгийн соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын асуудал эрхэлсэн агентлаг, театр, музей, номын сан, сумын соёлын төв, соёлын ордны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг зөвшилцсөний үндсэн дээр Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаар гүйцэтгүүлэн, тайлан мэдээг соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын асуудал эрхэлсэн яаманд хүргүүлж, үр дүнг тооцож ажиллана.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1. Гэрээний дөрөвдүгээр хэсэг болон гэрээний хавсралтад заасан арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг хагас (2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор), бүтэн (12 дугаар сарын 05-ны дотор) жилээр www.new.unelgee.gov.mn цахим системд оруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд тайлагнана.

5.2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаас эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн тайланг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан журам, маягтын дагуу гаргаж, тайлагнана.

5.3. Шинээр 2026 онд төлөвлөх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, газрын зөвшөөрөл, батлагдсан зураг, төсвийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор www.publicinvestment.gov.mn цахим системээр ирүүлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

6.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Нэмэлт, өөрчлөлт оруулах бол Талууд бичгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД

Ч.НОМИН




ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Б.ЗОРИГБАЯР




Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний нэгдүгээр хавсралт



НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа
Нэг. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр						
1.1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын чиглэлээр харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний стратеги төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Батлагдсан баримт бичиг, хэрэгжилт, хувиар	-	1 100	I, II, III, IV улиралд
1.2	Салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах, байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Улс, орон нутгийн төсөв	Бэлтгэсэн мэргэжилтний тоо, Чадавхжуулах сургалтын тоо, Нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн дүн	-	10 5 хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
1.3	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын байгууллагад ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийн дагуу хариуцлага тооцож, тайлагнах	-	Хэрэгжилт, хувиар	-	100%	I, II, III, IV улиралд

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хоёрдугаар хавсралт



СОЁЛ, УРЛАГ, СОЁЛЫН ӨВИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа
Нэг. Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр						
1.1	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, парк, цогцолбор, кластер, инкубатор хөгжүүлэх чиглэлээр газар эзэмших эрх олгох.	Орон нутгийн төсөв	Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон эсэх	-	Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
1.2	Хувийн хөрөнгө оруулалтаар аймгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж буй иргэн, хуулийн этгээдийн санал санаачилга, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийн тоо	-	10	I, II, III, IV улиралд
1.3	"Бүх нийтийн соёлын боловсрол II" арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	"Бүх нийтийн соёлын боловсрол I"	10 хүн амын 20-оос доошгүй хувь	II, III, IV улиралд
1.4	Номын сангийн сан хөмрөгийг баяжуулахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Баяжилт хийсэн номын тоо	-	Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
1.5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	-	100	I, II, III, IV улиралд
1.6	Орон нутгийн кино зураг авалтын онцгой байршлын жагсаалтад багтсан байгалийн үзэсгэлэнт газрыг гадаад, дотоодод сурталчилж, кино үзвэрийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Гэрээ байгуулсан Соёлын төвийн тоо	1	1	I, II, III, IV улиралд
			Кино үзэгчдийн тоо	173	1500	I, II, III, IV улиралд

1.7	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зусланд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагаанд салбар дундын уялдааг хангаж, дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Байгууллагын тоо хэмжээ Хамрагдсан хүүхдийн тоо	-	2 Хүүхдийн 30%	I, II, III, IV улиралд
1.8	Монголын үндэсний утга зохиолыг хөгжүүлэх, утга зохиол судлал, зохиолч, яруу найрагчдыг дэмжих.	Орон нутгийн төсөв	Утга зохиол, судлалд дэмжлэг үзүүлсэн байдал	2	3	I, II, III, IV улиралд
1.9	"Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд"-2025-ыг тэмдэглэн өнгөрүүлэх, номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжилт, хувиар	-	100	II, III улиралд
1.10	"Эх хэлний өдөр", "Үндэсний хувцасны өдөр"-ийг түгээн дэлгэрүүлж, төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөхөд албан хаагчдыг сургах, албан байгууллага, гудамж, талбайн нэрийг хос бичгээр хаяглах " Үндэсний бичиг, үсгийн баяр"-ыг тэмдэглэж, бичиг үсгийн соёлыг сэргээж, сурталчлан таниулах нөлөөллийн ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Улс, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хамрагдсан хүний тоо, Хаягжилт	Үндэсний бичиг үсгийн баяр-2024, Эх хэлний өдөр-2024, "Хос бичигтэн байгууллага" арга хэмжээг хэрэгжүүлсэн.	Байгууллага тус бүрд 2 Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
1.11	Бүх нийтийн соёлын боловсрол, "Нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх цогц ажлууд, нөлөөллийн аян" зохион байгуулах.	Улс, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хүн амын 1%-д хүрсэн байх	-	2 1%	I, II, III, IV улиралд
1.12	Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн тоо	5	Уралдаан 5 Уран бүтээлч 15	I, II, III, IV улиралд
Хоёр. Соёлын өвийг хадгалж, хамгаалах чиглэлээр						
2.1	Аймгийн нутаг дэвсгэрт орших улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нөхцөл байдлын үнэлгээ хийх, хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах.	Орон нутгийн төсвөөс	Объектын тоо Гэрээний тоо	БСШУС-ын 2020 оны "Жагсаалт батлах тухай" 160 дугаар тушаал	Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
2.2	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн өвлөн уламжлагчийн тоо	-	10	I, II, III, IV улиралд

2.3	“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Фестивальд оролцсон эсэх Зарцуулсан төсөв	“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг 2024 онд оролцсон.	Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
2.4	Үндэсний, уламжлалт хоол идээ ундаа улирлын онцлогт тохируулан сэргээн уламжлуулах ажлыг сумын Засаг даргын гэрээнд тусгаж, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах	Орон нутгийн төсвөөс	Уламжлалт хоол, идээ ундааны төрөл зүйл, хамрагдсан хүний тоо	“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалын үеэр зохион байгуулсан.	5 Хэрэгжилтээр	I, II, III, IV улиралд
2.5	Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг сум бүрд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсвөөс	Зохион байгуулсан өвийн тоо Хамрагдсан суралцагчийн тоо	-	5-аас доошгүй 100	I, II, III, IV улиралд
2.6	Соёлын төв, соёлын ордонд “Угийн бичгийн танхим” байгуулж ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсвөөс	Танхимын тоо хүний тоо	-	10 60	I, II, III, IV улиралд

---oOo---


Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний гуравдугаар хавсралт



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа
Нэг. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр						
1.1	Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдагчдыг 2 хувиар нэмэгдүүлж, залуучуудыг оролцоог хангах	Улсын төсөв	арга хэмжээнд хамрагдагчдын тоо	18,783	19,159	I, II, III, IV улиралд
1.2	Спортын тамирчдыг 1 хувиар өсгөх	Улсын төсөв	спортын тамирчдын тоо	8,916	9,005	I, II, III, IV улиралд
1.3	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 1 хувиар нэмэгдүүлэх	Улсын төсөв	сорилд хамрагдсан хүний тоо	8,914	9,003	I, II, III, IV улиралд
1.4	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А, В, С үнэлгээтэй хүнийг 1 хувиар нэмэгдүүлэх	Улсын төсөв	А, В, С үнэлгээтэй хүний тоо	6,728	6,795	I, II, III, IV улиралд
1.5	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоо	Орон нутгийн төсөв	суманд ажиллаж буй арга зүйчийн тоо	1	2	I, II, III, IV улиралд
1.6	Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр байгуулах	Орон нутгийн төсөв	өсвөрийн шигшээ баг байгуулсан спортын төрлийн тоо	16	16	I, II, III, IV улиралд
1.7	Тухайн орон нутагт дэлгэрээгүй* спортын төрлийг шинээр хөгжүүлэх	Улсын төсөв	хөгжсөн шинэ спортын төрлийн тоо	5	6	I, II, III, IV улиралд
1.8	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн биеийн тамир, спортын үйлчилгээний цэг**ийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв	шинээр бий болсон хувийн хэвшлийн спортын үйлчилгээний цэгийн тоо	1	2	I, II, III, IV улиралд
1.9	Орон нутгийн онцлогт нийцүүлэн Үндэсний спортыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх	Орон нутгийн төсөв	арга хэмжээний тоо	-	1	I, II, III, IV улиралд


Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа
Нэг. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр						
1.1	Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг төр хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах.	Орон нутгийн төсөв	арга хэмжээний тоо	0	100	0
1.2	Аялал жуулчлалын үйлчилгээний чанар стандарт, хүний нөөцийг чадавхыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах /Бүсийн хэмжээнд/	Орон нутгийн төсөв	сургалтад хамрагдсан хүний тоо	0	50-аас дээш	0
1.3	Орон нутгийн зочид буудлуудын үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах арга хэмжээ авсан байх	Орон нутгийн төсөв	аттестатчилалд хамрагдсан аж ахуйн нэгжийн хувь	3	5	3
1.4	Орон нутгийн онцлогт тулгуурлан шашин, соёл, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах	Орон нутгийн төсөв	арга хэмжээний тоо	0	5	I, II, III, IV улиралд
1.5	Ай Ти Эм Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллах	Орон нутгийн төсөв	дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	0	5	I, II, III, IV улиралд
1.6	Аймгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексийг дээшлүүлэх	Орон нутгийн төсөв	дээшилсэн байр	-	2-оос дээш байр	I, II, III, IV улиралд

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Орхон аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний тавдугаар хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа
Нэг. Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр						
1.1	“Залуучуудын соёлын фестиваль”-ийг нутаг дэвсгэрийн хэмжээнд Засаг даргын ивээл дор зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Хамрагдсан арга хэмжээний тоо, залуучуудын тоо,	0	1 1000	III улиралд
1.2	Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	0	2	I, II, III, IV улиралд
1.3	Аймгийн хэмжээнд “MNS7012:2023 Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт”-н хэрэгжилтийг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжилтийн хувь	0	50	I, II, III, IV улиралд
1.4	Залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, аливаа урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Улс, орон нутгийн төсөв	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	12	15	I, II, III, IV улиралд
1.5	Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийсэн, идэвх санаачилга гарган нийгэмд манлайлал үзүүлсэн хуулийн этгээд, иргэдийг алдаршуулах	Орон нутгийн төсөв	Алдаршуулсан байгууллагын тоо	0	5	I, II, III, IV улиралд
1.6	Зэвсэгт хүчин, дотоодын цэрэг, цагдаа, онцгой байдлын албаны залуучуудыг чадавхжуулах “Эх оронч залуу” хөтөлбөр хэрэгжүүлэх	Улс, орон нутгийн төсөв	Хамрагдсан залуучуудын тоо	100	250	I, II, III, IV улиралд